

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ХҮН АМ ЗҮЙ, ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭРДЭНЭБУЛГАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Хүн амын бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагын ялгаатай байдалд нийцүүлэн, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана.							
1	1.1.Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлнэ.	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж, үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэний тоо	79800	70000	Харъяалагдах чиг үүргийн байгууллага болох ХХҮГ-аас Нийгмийн халамжийн сангаас 1.6 мянган хүнд 5.5 тэрбум төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2.4 мянган хүнд 5.9 тэрбум төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 2.4 мянган хүнд 1.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж, 9.7 мянган ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 1.3 тэрбум төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хүн амын хөгжлийг дэмжих чиглэлийн улсын төсвийн санхүүжилтээр 63.7 мянган хүнд 43.9 тэрбум төгрөгийн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт олгосон байна. Өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 1.3 хувиар, олгосон халамжийн	2024.01.01-2024.12.31	100%

					хэмжээ 9.1 хувиар нэмэгдсэн байна. Давхардсан тоогоор 80441 иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээг хүргэхэд ажилласан.		
2.	1.2.Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хуулийн хүрээнд чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэнэ.	Мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	376	300	Тайлант хугацаанд нийгмийн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 137.9 сая төгрөг батлагдсан. Онцгой тохиолдлын тэтгэмжид 48 иргэнд 57.6 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд 5 төрийн бус байгууллагатай хамтран давхардсан тоогоор 355 иргэнийг хамруулж 80.3 сая төгрөгийг зарцуулсан. Зорилтот арга хэмжээнд нийт 403 иргэнийг хамруулж 137.9 зарцуулагдсан. ХХҮЕГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/12 тушаалаар ОНОТХҮ-ний аргачлал, нэг иргэнд ноогдох үйлчилгээний тарифт үнэ 50-100%-аар нэмэгдэж батлагдсан төсөвтөө багтаан үйлчилгээг үзүүлэх үүрэг чиглэл ирснээс шалтгаалан үйлчилгээнд хамрагдах иргэдийн тоо 2024 оны төлөвлөгөөнд тусгасан хэмжээнд хүрээгүй	2024.01.01-2024.12.31	70%
3.	1.3. Аймгийн Нийгмийн халамжийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Зөвлөлийн хурлын тоо, хамрагдсан иргэдийн тоо	4/120	4/110	2024 оны орон нутгийн халамжийн сангийн санхүүжилтийг 35.0 сая төгрөгөөр аймгийн ИТХ-аар батлуулсан. Нийгмийн халамжийн тухай хуулийн заалтыг үндэслэн баг, сумдын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийг харгалзан үзэж нийгмийн халамжийн	2024.01.01-2024.12.31	87.2%

					хуульд заасан тэтгэвэр тэтгэмж олгох, бусад үйлчилгээнээс бусад орон нутгаас үзүүлж буй халамжийн үйлчилгээнүүдийг тухайлбал буцалтгүй тусламж, гэр олгох зэрэг ажлыг зохион байгуулдаг. Аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нарт хандаж буцалтгүй тусламж хүсч өргөдөл ирүүлсэн нийт 96 иргэний өргөдлийг аймгийн Нийгмийн халамжийн зөвлөлийн 4 удаагийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж 35.0 сая төгрөг олгосон. Иргэдийн данс мэдээлэлд тулгалт хийх, санхүүжилтийн гүйлгээ хийх, иргэдэд эргэн мэдээлэх, и-оффисд өргөдлийг хаах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан.		
4.	1.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаанууд хэрэгжүүлнэ	Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл нь тайлант хугацаанд дүрэмд заасны дагуу хуралдаж, жилийн ажлын төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэн ажиллав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төвүүд болох Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны Орхон салбарын дэргэдэх “Гэрэл” төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Найдвар” төв, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалтын “Сорхугтани” төв, аутизм хэл заслын холбооны “Пондолдой” төв, Хөгжлийн	2024.01.01-2024.12.31	100%

					бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлт сургалтын төв зэрэгт 318.2 сая төгрөгийн дэмжлэг, Хүмүүн бие даан амьдрах төвийн “Хувийн туслах” үйлчилгээ төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд 64.3 сая, “Тэгш боломж” төсөлд 350.0 сая, салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалл 40.0 сая төгрөг, нийтдээ орон нутгийн төсвөөс 627.5 сая төгрөг тус тус зарцуулсан. 2024 онд тус төслийг 7,17,16 дугаар сургуулиудад үргэлжлүүлэн хэрэгжүүлж аймгийн хэмжээнд нийтдээ 9 сургууль “Хүүхдийн хөгжлийн танхим”-тай болсон. Төлөвлөгөөт ажлын хүрээнд Дохионы хэлний сургалт явуулах, Дэмжлэгийн багийг чадавхижуулах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисст дэмжлэг үзүүлэх, сургалт нөлөөллийн ажил, өдөрлөг арга хэмжээ, уулзалт хэлэлцүүлэг, сарын аян зэрэг зэрэг 30 гаруй ажлуудыг 7 төрийн байгууллага, 10 ТББ-тай хамтран зохион байгуулж 280 гаруй байгууллагад нөлөөллийн ажил хийж, 1000 гаруй хүнийг хамруулсан.Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ХНХЯ болон ХБХХЕГ-т хүргүүлсэн.Төлөвлөгөөт ажил 100%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	
--	--	--	--	--	---	--

Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.	2.1.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мэргэжлийн сургалтад хамруулан, ажилд зуучлах үйлчилгээг хэрэгжүүлэх	Нийтлэг үйлчилгээнд хамрагдсан иргэд, ажилд зуучлагдсан иргэдийн тоо	2696	2300	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, хөдөлмөрийн насны ажилгүй иргэдийг сургах, чадавхижуулах чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд 3322 иргэнд 14.0 сая төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 894 иргэнд 612.9 сая төгрөг, үндэсний зөвлөлөөс батлагдсан туршилтын төсөл, дэмжих хөтөлбөрт 192 иргэнд 220.4 нийт 4408 иргэнийг хамруулж 847.3 сая төгрөг зарцуулсан. 2024 онд 1080 иргэн ажилд зуучлагдсан. Тайлант хугацаанд нийт 898 ажлын шинэ байрыг бүртгэсэн. Хөдөлмөрт бэлтгэх суурь ур чадварын сургалтыг Улаанбаатар хотын “Эм эс девелопмент консалтинг” ХХК-ийн дэргэдэх сургалтын төвтэй гэрээлэн зохион байгуулж, сургалтад Баян-өндөр сумын нийт 150 иргэнийг хамруулж 4.5 сая төгрөг зарцуулсан. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг нийт 206 иргэн байгаагаас хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 102 иргэн, нийгмийн халамжийн дэмждэг туслалцаа шаардлагатай өрхийн 94 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй 10 иргэн тус тус хамрагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн цахим бүртгэлийн Ejob цахим платформыг ажил хайгч, ажил	2024.01.01-2024.12.31	100%
----	---	--	------	------	---	-----------------------	------

					олгогчдод тогтмол сурталчлан танилцуулж, Орхон Политехник коллежийг төгсөж байгаа нийт 224 төгссөгчдийн дунд зохион байгуулсан “Нэг төгсөгч нэг ажлын байр” арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг танилцуулж, Ejob.gov.mn программыг сурталчилан ажил хайгчаар бүртгэсэн. “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” өдөрлөг арга хэмжээ Жаргалант суманд зохион байгуулж, өдөрлөгт оролцогч Жаргалант сумын залуучууд, малчид, иргэд, ажил олгогч нарт хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн цахим систем Ejob платформ танилцуулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг сурталчилсан. Өдөрлөгт Жаргалант сумын нийт 86 малчид, иргэд, тариаланчид Жаргалант сумын томоохон аж ахуй нэгж байгууллага оролцов. 2024 оны 09 дүгээр сард Амарын талбайд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх, ажил олгогч байгууллагууд, ажил хайгч иргэдийн уулзалтыг зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдээ мэдээллийг иргэдэд өгч , хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын оролцоог дэмжиж үзэсгэлэн худалдаанд оролцуулах, хөдөлмөр эрхлэлтийн		
--	--	--	--	--	---	--	--

					мэдээллийн нэгдсэн цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн нэгдсэн бодлого арга хэмжээг иргэдэд хүргэх, зорилготой хөдөлмөрийн яармаг өдөрлөгийг зохион байгуулсан.		
2.	2.2.Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр арга хэмжээний хүрээнд бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн арга хэмжээнд хамрагдаж байнгын болон түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо	101	100	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг 2 үе шаттайгаар зохион байгуулж нийт 43 иргэнд 345.0 сая төгрөгийг 50-100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 24-36 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй санхүүгийн дэмжлэгийг олгосон. Үүний үр дүнд 70 ажлын байр хадгалагдаж 59 шинэ ажлын байр бий болсон байна.	2024.01.01-2024.12.31	59%
3.	2.3.Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөл зэрэг нийгмийн түншлэгч талуудын оролцоо бүхий зөвлөлүүдийн үйл ажиллагааг Ажлын албатай хамтран жигд үйл ажиллагаагаар хангаж ажиллах	Зөвлөлүүдийн хурал, жилийн төлөвлөгөө, хийгдсэн үйл ажиллагааны гүйцэтгэл хувь	100%	100%	Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл 2 удаа хуралдаж хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 2024 онд хийх ажлын төлөвлөгөө болон сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэгт орж ажиллах тухай ажлуудын талаар хэлэлцэж, санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтанд Ажлын хэсэгт орж ажилласан. Аймгийн ХАБЭА-н зөвлөл тайлант хугацаанд 2 удаагийн хурал зохион байгуулсан. 2024 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс хийх ажлын төлөвлөгөөнд	2024.01.01-2024.12.31	100%

					туссан 4 ажлыг зохион байгуулж 10.0 сая төгрөг, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнд туссан 25 арга хэмжээг зохион байгуулж 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд 11 үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Нийгмийн түншлэлийн талуудын байгууллагууд болон Нийгмийн даатгалын хэлтэс, Жаргалант сумын ХАБЭА-н зөвлөлтэй хамтран ажиллаж, сарын аяны нээлтийн үйл ажиллагааг "Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе" уриан дор зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд нийт 5 сургалт, 2 төрлийн зөвлөмж, малчдад зориулсан гарын авлага, үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилчдын дурсгалыг хүндэтгэх зул өргөх үйл ажиллагаа, халуунаас үүдэлтэй стресс, бухимдлаас урьдчилан сэргийлэх баннер зэргийг хийж бэлтгэн нийгмийн түншлэлийн 3 талын цахим хуудас болон https://hab.erdenet.mn/ веб сайт, ETV телевиз, цахим орчинд түгээсэн. Бэлтгэсэн зөвлөмжийг сургалтад хамрагдсан иргэд болон томоохон худалдааны төв, 30 гаруй байгууллагын 10000 гаруй ажилтан албан хаагч нарт хүргэсэн. 2024 оны	
--	--	--	--	--	--	--

					арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ХАБЭА-н ерөнхий ойлголт, ХАБЭА-н тухай хууль, асбестын хор нөлөө, эрсдэлийн үнэлгээний арга зүй сэдвүүдээр 5 байгууллагын 206 ажилтан албан хаагчдад 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. 2024 оны байдлаар 25 ба түүнээс дээш ажиллагчидтай нийт төрийн болон хувийн хэвшлийн 71 байгууллагад 6128 хүн ажиллаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй 245 иргэн ажиллаж байна. Ажиллавал зохих 16 байгууллагад 34 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүй төлбөрийн нэхэмжлэлийг хүргүүлж, 839.0 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	1.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулах	Иргэдийн үнэмлэхийг чирэгдэлгүй олгосон байна	3000	1800	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаалаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам"-ыг үндэслэн	2024.01.01- 2024.12.31	100%

					аймгийн ЗДТГ-т үнэмлэх баталгаажуулалтын ажлыг зохион байгуулж байна. Үнэмлэх олгохдоо хүүхдэд бол “хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс”-ын шийдвэрийг үндэс болгож байна. Баян-Өндөр болон Жаргалант сум иргэдэд зарыг хүргэж, материалуудыг хүлээн авах, хүргүүлсэн маягтын дагуу хүснэгтийг бөглөж бүртгэлийг хийж үнэмлэхийг авчирснаар үнэмлэхийн бичилт хийж, гарын үсэг зурж, баталгаажуулах ажил хийгддэг. 2024 онд нийтдээ 3257 үнэмлэх мэдээллийн санд бүртгэгдсэн ба шинээр 850 үнэмлэх, сунгуулах 1800 нийтдээ 1890 үнэмлэх баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, баримтуудыг архивын нэгж болгон байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.		
2.	1.2.ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад	Хэрэгжилтийн Хувь	90%	90%	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2023 оны 1-р улиралд батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	2024.01.01- 2024.12.31	92.1%

	тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх						
3	1.3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжийн хэрэгжилт	0	Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх	Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эхний хагас жилд хэлтсийн бичиг хэргийн хөтлөлтийг хариуцан ажиллаж нийт 218 ирсэн бичиг, 182 өргөдөл, Засаг даргын 5 шуурхайн үүрэг даалгавар зэргийг тухай бүрт холбогдох ажилтанд шилжүүлэх, хугацаанд хяналт тавих ажлыг хариуцан гүйцэтгэсэн. 2024 оны 08 дугаар сараас 10 сар хүртэлх хүртэлх хугацаанд хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэж хурал, зөвлөгөөн, арга хэмжээ, бичиг хэрэг хөтлөлт, удирдан зохион байгуулалтын ажлуудыг гүйцэтгэсэн.	2024.01.01- 2024.12.31	90%
4	1.4 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	100%	100%	Иргэдээс ирүүлсэн буцалтгүй тусламжийн 96 өргөдлийг шийдвэрлэж, гэр хүссэн 80 өргөдөлийг тайлант гэр бэлтгэн	2024.01.01- 2024.12.31	100%

	хугацаанд шуурхай шийдвэрлэх				нийлүүлэгдээгүй тул гэр олгох боломжгүй хариуг өгч ажилласан.		
5.	1.5. Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо	8	Шийдвэрийн дагуу ажилласан байна	Өөрийн хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд 185 албан бичиг, 176 өргөдөл хүлээн авч шийдвэрлэлтийг хангаж ажилласан. Ирсэн бичиг болон цаг үеийн үйл ажиллагаануудтай холбогдуулан 474 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан.Тайлант хугацаанд 25 үүрэг даалгавар хүлээн авч, шийдвэрлэлт хангаж ажилласан.Мөн аймгийн Засаг даргын 22 захирамж гаргасан. Засаг даргын захирамж болон, ЗДТГ-ын даргын тушаал бусад хэлбэрээр байгуулагдсан 9 ажлын хэсэгт орж ажилласан. УИХ болон орон нутгийн сонгууль зохион байгуулах хэсгийн хороонд даргын үүрэг гүйцэтгэж ажилласан.	2024.01.01-2024.12.31	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.							
1.	2.1.1. Албан тушаалын тодорхойлолтод	Сургалтуудад хамрагдсан байх	Гадаад 1, дотоодын 4	Танхим-2	ТАЗ, ХНХЯ-наас зохион байгуулсан цахим сургалтуудад хамрагдсан. Хүний эрхийн комиссын цахим	2024.01.01-2024.12.31	100%

	тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах		удаагийн сургалт	Цахим -10-аас доошгүй	тайлант хуралд нийгмийн салбарын байгууллагууд, ТББ-уудын төлөөлөлтэй хамтран оролцсон. Монголын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны хүсэлтээр 21 аймаг, 9 дүүргийн холбоод болон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлүүдийн төлөөлөл оролцсон цахим сургалтанд "Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуус эрхээ эдлэх нь" сэдвээр Орхон аймагт хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн. Удирдлагын академиас зохион байгуулсан "Мега хотын засаглалын шинэчлэл" сэдэвт сургалтанд цахимаар хамрагдсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал Бодлого, үйл ажиллагаа" мэдээллийн лавлах номд оруулах Орхон аймгийн мэдээллийг гарган хүргүүлсэн. "Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал" цахим сургалт, ИТХ-аас зохион байгуулсан "Чанарын форум-2024" зэрэг сургалт, арга хэмжээнүүдэд оролцсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн төлөвлөгөөт ажлын хүрээнд эцэг, эх асран хамгаалагчидтай уулзалт зохион	
--	--	--	------------------	-----------------------	--	--

					байгуулж, сургалт хийсэн. Улаанбаатар хотноо 2024 оны 2 дугаар сарын 1, 2-ний өдрүүдэд зохион байгуулагдах Бүсчилсэн хөгжлийн чуулганд оролцсон. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил" төсөл Баян-Өлгий, Ховд аймагт хэрэгжиж байгаа ба Баян-Өлгий аймагт урьж хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр орон нутагт бодлого зохицуулалтын түвшинд хийгдэж буй ажлууд танилцуулах, хүүхэд, залуусыг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлууд, хүүхдийн боловсролд тэгш хамрагдалтыг дэмжих чиглэлийн ажлуудын сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх санал солилцох, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх албан хүсэлт ирүүлсний дагуу Баян-өлгий аймагт 2024 оны 04 дүгээр сарын 30-наас 2024 оны 05 дугаар сарын 04 хүртэл хугацаанд ажлын 3 өдөр ажилласан. Уг арга хэмжээний хүрээнд Баян-Өлгий, Ховд аймгуудын Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл болон ХБХЭМБНХ-ын салбар комиссын гишүүд болон сумдын төлөөлөл мөн цэцэрлэгийн дэмжлэгийн баг бүрэлдэхүүнд сургалт явуулж, 2 цэцэрлэг, 1 сургуульд арга зүйн зөвлөгөө дэмжлэг байгууллагад нь очиж зөвлөн тусласан. Нийт	
--	--	--	--	--	---	--

					сургалтанд 80 гаруй байгууллагын 100 гаруй хүмүүс хамрагдаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг авсан. Удирдлагын академийн Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт, үр дүнд суурилсан төлөвлөлт, Манлайлалын ур чадвар дээшлүүлэх сургалтуудад хамрагдаж сертификат авсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо үндэсний чуулганд ТББ-уудын төлөөллийн хамт оролцов. 7:9:11 цахим сургалтуудад 7 хоног бүр хамрагдсан.		
--	--	--	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ХҮН АМ ЗҮЙ, ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

 **Г.ЭРДЭНЭБУЛГАН**